

Шинжлэх Ухааны Академи  
Олон Улс Судлалын Хүрээлэн

# ЭРДМИЙН ДАЛАЙ

*Редактор доктор (Sc.D), профессор Л.Хайсандай*  
*Найруулан эмхэтгэж, хянан тохиолдуулсан*  
*доктор (Ph.D), профессор Л.Бэгзжав*

Улаанбаатар  
2010 он

DDC  
928.951 7  
Э-733

*Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Д.Золбоо,  
Ш.Догмийчойдон  
Хавтасны дизайныг Н.Алтантөгс  
“Хас принт” ХХК-д 300 хувь хэвлэв.*

**Хаяг:**

ШУА-ийн Олон Улс судлалын хүрээлэн,  
Чингэлтэй Баруун Сэлбэ - 17  
Шуудангийн хайрцаг -187  
Улаанбаатар -211238  
Монгол Улс  
Утас: 322613, 325571, 317185, 318691  
Факс: (976-11) 322613  
E-mail: [info@iis.mas.ac.mn](mailto:info@iis.mas.ac.mn)  
вэб хуудас: [www.iis.mas.ac.mn](http://www.iis.mas.ac.mn)

ISBN 978-99929-959-6-3

✓ Лю Динань, Ц.Ганбаатар	Монгол, Хятад соёлын харилцааны элч академич Ч.Далай ( <i>Хятад хэлнээс орчуулсан Д.Батжаргал, Л.Бэгзжав</i> )	86
Т.Молотов О.Пүрэв	Их түүхээ эрхэмлэсэн нэрт эрдэмтэн Монголын бөө мөргөлийн судлал ба академич Ч.Далай	98 104
Ж.Болдбаатар, С.Цолмон	Чулууны Далай (1931-2009 он)	108
Д.Золбоо Ц.Энхбат	Түүхийн Далай багш минь Миний өвөө төлөвлөгөөгөөр төрсөн эрдэмтэн биш, Төрөлхөөсөө заяасан эрдэмтэн хүн юм	114 116
С.Жаргалсайхан С.Дамдинсүрэн	Эгэл даруухан, энгүүних далай багш Академич Ч.Далайн дурсгалд	121 124
Г.Бямбасүрэн Ц.Өнөрбаян	Ч.Далай багшдаа Дуурайх сайхан үйлстэн	127 129
На.Сүхбаатар Ц.Гантулга	Ч.Далай багштайгаа ойрад судлалаар холбоотой болсон Академич Чулууны Далай хэмээх эрхэм хүмүний тухай дурсамжинд дусал нэмэрлэхүй	131 134
Э.Пүрэвжав Б.Энхчимэг	Академич Ч.Далай багшийн дурсамж Багшаа дурсахуй Дипломат албанд зүтгэсэн онжилүүд Академич Чулууны Далайн эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт	139 141 142 165

## МОНГОЛ, ХЯТАД СОЁЛЫН ХАРИЛЦААНЫ ЭЛЧ АКАДЕМИЧ Ч.ДАЛАЙ

*Лю Динань\**  
*Ц.Ганбаатар\*\**

2009 оны 6 сард, зохиогч миний бие монголын нэрт түүхч, дипломатч, академич Ч.Далай гэнэт бурхан болсон цочирдом мэдээг сонсоод биеэ барьж тэсээгүй. Би академич Ч.Далайн сургуулийн найз болохын хувьд монголын алдартай эрдэмтэний дурсгалд зориулж үүнийг тэрлэлээ.

2009 онд Монгол, Хятад хоёр орны дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ой болов. 60 жилийн турш хоёр орны улс төр, эдийн засаг, соёл зэрэг бүхий л салбарын харилцаа ихээхэн хөгжсөн. Ялангуяа соёлын харилцааны хөгжил нь хоёр улсын харилцааны чухал бүрэлдэхүүн юм. Хоёр улсын соёлын харилцааг хөгжүүлэхэд эрдэмтэн, соёлын ажилтан болон дипломатчид цуцалтгүй хүчин чармайлт гаргасаар байна.

1952 онд, шинэ Хятад улс байгуулагдсаны 3 жилийн ойн үеэр, "Монгол, Хятадын эдийн засаг болон соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр"-т гарын үсэг зурсан юм. Уг хэлэлцээрийн дагуу 1952 оноос Хятад, Монгол хоёр орон харилцан оюутан солилцож эхэлсэн. Тэр жил анх Хятадад Монголоос гурван оюутан Бээжингийн Их Сургуульд суралцахаар очсон.<sup>1</sup> Үүнээс хойш монгол оюутны тоо жил бүр нэмэгдсэн. Монголын нэрт эрдэмтэд тухайлбал: Ч.Далай, Н.Ишжамц, Л.Жамсран, Р.Нямаасүрэн, Л.Манлажав, Г.Сүхбаатар, Чой. Лувсанжав нар бүгд л залуу насандаа Бээжингийн их сургуульд суралцсан юм. Бээжингийн их сургуульд суралцсан он жилүүд эдгээр эрдэмтдийн судалгаа шинжилгээнд гүн гүнзгий нөлөө үзүүлж, тэд монгол улсад олон шилдэг Хятад судлаач эрдэмтэн бэлтгэхэд, мөн Хятад, Монголын соёлын харилцааны гүүр болж соёлын харилцаанд асар их хувь нэмэр оруулсан юм. Монгол улсын нэрт түүхч, дорно дахиныг

\* Лю Динань - Бээжингийн Их Сургуулийн гадаад хэлний дээд сургуулийн Монгол судлалын төв

\*\* Ц.Ганбаатар - МУИС-ийн багш, 2007 оноос Бээжин их сургуулийн түүхийн факультетэд докторант. 2010 онд нас нөхцөв.

судлаач эрдэмтэн, Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн академич Ч.Далай бол тэдгээрийн шилдэг төлөөлөгч мөн.

### 1. Академич Ч.Далайн Бээжингийн их сургуулийн оюутан үеийн амьдрал

Академич Ч.Далай 1929 онд<sup>2</sup> БНМАУ-ын баруун хязгаарын Ховд аймгийн Зэрэг сумын малчны гэрт төржээ. 1950 онд дунд сургуулиа төгсөөд багш болж, удалгүй нийслэл Улаанбаатарт ирж монголын хамгийн том сургууль болох Монгол Улсын Их Сургуульд<sup>3</sup> түүхч мэргэжлээр суралцжээ. 1952 онд, сурлага сахилга сайтай Ч.Далайд Хятад улсын Бээжингийн их сургуульд суралцах сайхан боломж олдсон юм. Үүнээс хойш хятадтай саяшгүй холбоотой болжээ. Бээжингийн их сургуулийн архивт хадгалагдаж байгаа 1952 оны гадаад оюутны бүртгэлд академич Ч.Далайн Бээжингийн их сургуульд ирж сурч байх үеийн тухай: Нэр: Ч.Далай, Аль улс: Монгол, Суралцсан байдал: Түүхийн салбар 1-р анги (мөн 2 жил орос хэл сурсан). Сургуулийн санал: Монгол улсын их сургуульдаа дэлхийн түүх, ЗХУ-ын түүх, монголын түүх, марксизм-ленинизмийн үндэс зэргийг үзсэн. 3-р ангид 2 жил сурах, дараа нь дахин 1 жил 1, 2-р ангийн хичээлийг нөхөн үзэх, Тэнхимийнхэн түүнийг иймэрхүү дэс дараалалаар түүхийг сурч чадахгүй тиймээс түүнийг 2-р ангиас оруулъя, мөн 1-р ангийн хятадын түүхийн хичээл нөхөж, дэлхийн түүхийн хичээлээс чөлөөлж болох юм<sup>4</sup> гэжээ. Академич Ч.Далай Бээжингийн их сургуулийн түүхийн салбарт 6 жил сурч, амьдарсан түүх ингэж эхэлсэн юм. Эхний 2 жилд тэрээр хятад хэлний тусгайлан мэргэших ангид хятад хэл бичиг сурав. 1958 онд академич Ч.Далай Бээжингийн их сургуулийн түүхийн салбарыг бакалаварын зэрэгтэй төгсжээ.

Академич Ч.Далай Бээжингийн их сургуульд 6 жилийг эрдэм сурч, өнөөгийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бат бөх үндэс сууриа тавьжээ. Нас дээр гарсан ч тэрээр Хятадад сурч байх үеэ байнга л дурсдаг байв. 1998 онд, академич Ч.Далай нэгэн дурсамж өгүүлэлдээ: Биднийг анх гурвуулаа Бээжинд очиход халуун дотноор угтан хүлээн авсан. Одоо бодоход төрийн зочин мэт хүлээн авч байлаа. Бид анх Бээжинд ирэхдээ Хятадын тухай маш бага мэддэг байлаа. Үүний зэрэгцээ тэр үед цаг сайхан байсан.

БНХАУ байгуулагдаад ердөө 3 жил болж байв гэжээ.

Академич Ч.Далайг эргэн дурсахад, Бээжингийн их сургуулийн түүхийн салбарт сурах хугацаанд хятадын олон алдартай эрдэмтдээр хичээл заалгуулжээ. Жишээ нь: Жянь Бозан, Дэн Яомин, Жоу Илян, Сянь Да, Гао Минкай гэх мэт. Мөн Лю Шаоци, Жоу Энлай нарын тухайн үеийн Хятадын төрийн удирдагчид байнга л Бээжингийн их сургуульд ирж, багш нарыг зоригжуулж: Хятад улсыг хөгжүүлэхэд мэдлэг хэрэгтэй. Та бүгд цэцэглэн хөгжсөн Хятад улсыг харах болно. Энэ улсын ирээдүй та нарын л гарт байна гэж хэлдэг байлаа. Тэд ёстой л холын хараатай эрдэм мэдлэгтэй удирдагчид байв. Тэр үеийн сэхээтэнүүд, ажилчин, тариачидтай нягт холбоотой байсан юм. Гадаад оюутанд хатуу шаардлага гавьдаггүй байлаа. Академич Ч.Далай өөрийн хүслээрээ энгийн хятад тариачин айлд амьдарч газар тариалангийн ажил сурч, хятад улсын тухай мэдлэгээ нэмэгдүүлж байлаа.

1958 онд, академич Ч.Далай Бээжингийн их сургуулийг төгссөн жилээ "Монгол бөө мөргөлийн товч түүх"<sup>5</sup> гэсэн ном бичиж дараа жил нь Улаанбаатарт хэвлүүлжээ. Тус зохиол дотоод гадаадын эрдэмтдийн сонирхолыг ихэд татсан бөгөөд холбогдох салбарын мэргэжилтнүүдээс өндөр үнэлгээ авчээ. Уг бүтээл 1978 онд хятад хэл дээр<sup>6</sup> орчуулагдсанаас гадна, Франц, Герман, Япон зэрэг орны эрдэм шинжилгээний хэвлэлд уг бүтээлийн товчлол хэвлэгджээ. 1999 онд уг бүтээлээ уйгаржин монгол хэл дээр Хөх хотод хэвлүүлсэн ба уг зохиол нь монгол улсын бөө судлалын салхийг хагалсан томоохон бүтээл болсон гэж нийтэд үнэлэгджээ. Тухайлбал: Монгол Улсын төрийн шагналт зохиолч, академич Л.Түдэв ярилцлагадаа: 1959 онд дөчөөд жилийн тэртээ түүхч Чулууны Далайн "Монголын бөө мөргөлийн товч түүх" гэдэг бэсрэг судалгааны ном Улаанбаатарт хэвлэгдсэн юм. Тэр үедээ залуухан түүхч, одоо бол нэрд гарсан академич, доктор, профессор Ч.Далайн тэрхүү бүтээл монголчуудаас эртний шүтлэгийн тухай тодорхойлон бичсэн анхны эрдэм шинжилгээний ном байсны хувьд бөө мөргөлийн судалгааны тулгуур бичиг болж бараг хагас зуун жил ганцаарааа торойн байгаа билээ" гэжээ. Үүнээс гадна Хөх хотод хэвлэгдсэн уйгаржин монгол хэл дээрх зохиолын оршилд бичихдээ: "Монгол эрдэмтэд төдийгүй гадаадын олон орны судлаачид энэ зохиолыг өндрөөр үнэлсэн юм. Уг зохиол

бөө мөргөлийг судалдаг Хятадын эрдэмтдийн ширээний ном болсноос гадна ач холбогдол нь туйлын их юм”<sup>7</sup> гэж цохон тэмдэглэжээ. Энэхүү зохиол нь академич Ч.Далайн эрдмийн амьдралын анхны тулгын чулуу болсон төдийгүй түүнийг дотоод, гадаадын эрдэмтдэд таниулж өгсөн бүтээл юм. Тэрээр бүтээлээ Бээжингийн их сургуулийн эрдэмтэн, багш нарын удирдлагаар бичсэн билээ.

## **2. Академич Ч.Далайн судалгааны ажил Монгол, Хятадын соёлын харилцаанд тус дохөм үзүүлдэг**

20-р зууны 50 -иад оны сүүлээс өдгөө хүртэл хагас зуунд академич Ч.Далай Монголын түүх, Хятад судлал, дорно дахины судалгааг эрхэлжээ. 50 жилийн хугацаанд тэрээр хичээнгүйлэн сурч судлан, бийр бэхтэй нөхөрлөн, Монголын түүх, дорно дахины судалгаатай холбогдох олон тооны ном хэвлүүлсэн. 1962-1968 он, 1986-1989 онуудад академич Ч.Далай БНМАУ-аас БНХАУ-д суух Элчин сайдын Яаманд нарийн бичигийн дарга, элчин зөвлөх зэрэг ажлыг 10 шахам жил хашиж Монгол, Хятад хоёр орны дипломат харилцааг ахиулах, ялангуяа соёлын харилцааг хөгжүүлэхэд их хувь нэмэр оруулсан юм. Монголын ард түмэнд Хятад улсыг танилцуулж, Хятадын ард түмэнд Монгол улсыг танилцуулж, хоёр орны соёлын солилцоо, хөгжлийг урагшуулах нь Ч.Далайн бүхий л амьдралын чухал үйл хэрэг байлаа.

Академич Ч.Далайн гол судалгаанд Монголын түүх, Хятад судлал, дорно дахины судлал хамаардаг. Тэрээр залуудаа Бээжингийн их сургуулийн оюутан байхдаа үнэн сэтгэл, эрдэм чадлаа хятад хэл болон хятадын соёлд зориулсан. Бээжингийн их сургуульд сурч байх хугацаандаа болон дараа нь Хятадад дипломат албахаших үедээ монголын түүхийн холбогдолтой хятад хэл дээрх арвин их сурвалж бичиг материал цуглуулжээ. Эдгээр хятад хэл дээрх түүхийн эх сурвалжийг өнөөг хүртэл монголын

түүх, хятад судлал, дорно дахины судлал зэрэг олон талын судалгаа, танилцуулгандаа ашиглаж, хоёр улсын эрдэмтдийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын баг бэх үндэс суурийг тавьж өгсөн юм. Мөн түүний судалгаа шинжилгээний ажил нь хятад эх сурвалжийг ашиглан цуглуулах явцыг чухалчилан үзсэнээрээ онцлог юм. Тухайлбал: Академич Ч.Далайн шилдэг бүтээл болох «Монголын бөө мөргөлийн товч түүх»-ийг бичихэд “Түүхийн тэмдэглэл”, “Умард Хань улсын түүх”, “Вэй улсын түүх”, “Тан улсын шинэ түүх”, “Юань улсын түүх” зэрэг хятад хэл дээрх түүхэн материалыг өргөн ашигласан.

Академич Ч.Далай нь судалгаандаа олон хятад эх сурвалжийг ашиглаж, эдгээр материалаа Монголын судлаачдад танилцуулахад чармайлт гаргасан юм. 1958 оны намар академич Ч.Далай улсдаа буцаж, Монгол Улсын Их Сургуульд түүхийн мэргэжилээр багшилсан. 1959-1962 онд академич Ч.Далай «Монголын түүхэнд холбогдол бүхий хятад хэл дээрх эх сурвалж», «Монголын түүхэнд холбогдол бүхий хятадын эртний тулгуур судар бичиг» зэрэг хичээл зааж байв. Эдгээр хичээлүүд нь тухайн үеийн Монголын түүхчид, түүх сонирхогчдод чухал лавлагаа болж өгсөн юм.<sup>8</sup> Монголын түүх судлалын холбогдолтой олон түүхийн материал сурвалж бичиг хятад хэлнээс орчуулан бичиж, эмхлэн цэгцэлж хэвлүүлсэн нь Монгол улсын монголын түүх судлалд чухал ач холбогдолтой байв. 1959 онд академич Ч.Далай “Монголын түүхэнд холбогдол бүхий хятадын эртний тулгуур судар бичгээс танилцуулах нь”<sup>9</sup> гэсэн өгүүлэл бичсэн. Уг өгүүлэлд Сүн, Юань, Мин, Чин 4 улсын түүхээс Монголын түүхтэй холбоотой түүхэн эх сурвалжийг танилцуулжээ. Жишээ нь: “Хар татарын хэргийн тойм”, “Монгол татарын товч тэмдэглэл”, “Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл”, “Баруун хязгааралс аялсаны тэмдэглэл”, “Чан Чунь бумбын баруун хязгаараар зорчсоны тэмдэглэл”, “Баруун

этгээдэд зорчсоны тэмдэглэл”, “Юань улсын түүх”, “Юань улсын түүхийн төрийн эмхтгэл”, “Юн Лэ хааны их хууль”, “Юань улсын түүх”, “Юань улсын түүхийн нэмэлт орчуулга”, “Юань улсын түүхийн овог нэрийн хүснэгт”, “Монгол нүүдэлчдийн тэмдэглэл”, “Юань улсын судар”, “Монголын түүх”, “Юань улсын шинэ түүх” гэх мэт. Эдгээр түүхийн сурвалж бичгүүд нь Монголын түүхийн судалгаанд чухал материал болсон юм. Академич Ч.Далайн бүхий л бичсэн Монголын түүхийн хятад эх сурвалжийн танилцуулга нь монголын эрдэмтдийн монголын түүхийн холбогдолтой хятад хэл дээрх сурвалж бичигт нэвтрэх арга замыг заасан баримтлал болжээ.

1970 онд академич Ч.Далай “Юань гүрний үеийн Монгол”<sup>10</sup> гэсэн зохиолоороо түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ. “Юань улсын үеийн Монголын түүхийн судалгааны байдал” гэсэн өгүүлэлдээ тухайн үеийн монголын түүхтэй холбоотой олон хятад эх сурвалжаас болон Юань улсын үеийн Монголын түүхийн судалгааны байдлыг танилцуулжээ. Тус бүтээлдээ монгол, хятад, орос, япон, англи зэрэг хэл дээрх түүхийн эх сурвалжийг ашигласанаас хятад эх сурвалж болон судалгааны ном зохиол 85 байна.

1986 онд академич Ч.Далай “Монгол, Хятадын харилцаа: 1949-1984”<sup>11</sup> гэсэн сэдвээр докторын зэрэг горилох зохиолоо бичиж түүхийн шинжлэх ухааны доктор болсон. Тус зохиол нь Монгол, Хятад хоёр орны дипломат харилцаа тогтсоноос хойшхи хоёр орны харилцааг бүх талаар нь системтэй танилцуулсан анхны бүтээл болсноороо, Монгол, Хятад харилцааны түүхийн судлалд чухал ач холбогдолтой юм. Академич Ч.Далай мөн “БНМАУ дахь Хятад судлал” /1961 он/,<sup>12</sup> “Хятад болон Япон дахь Монгол судлал” (1968 он),<sup>13</sup> “Монгол улс дахь Ойрад судлал” /1995 он/<sup>14</sup> зэрэг зохиолоороо Монгол судлал ба Хятад судлалын талаархи

хоёр орны судалгааны байдлыг монгол, хятад эрдэмтдэд танилцуулсан.

“Хятад болон Япон дахь Монгол судлал” ном нь шинэ Хятад улс байгуулагдсанаас хойш 20-р зууны наяд он хүртэл Хятад улс дахь Монгол судлалын онцлог, судалгааны үр дүнг бүх талаар танилцуулсан байна. Зохиолдоо: Хятад улсын Монгол судлалын судалгааны хэд хэдэн төвийг дурджээ. Жишээ нь: Хятадын нийгмийн шинжлэх ухааны цөөн тоот үндэстний утга зохиолын хүрээлэн, Өвөр монголын их сургууль, Өвөр монголын багшийн их сургууль болон Бээжингийн их сургуулийн Монгол судлалын чиглэл, онцлог гэх мэтийн талаар дурджээ. Үүний зэрэгцээ Хятад улсын Монгол хэл судлал болон феодалын нийгмийн түүрүү үеийн Монголын түүхийн судалгааг тусгайлан үнэлжээ.

1991 онд академич Ч.Далайн “БНМАУ-ын Юань улсын түүхийн судалгаа ба (Юань улсын түүх)-ийг монгол хэл рүү орчуулсан нь” өгүүлэл хятад хэлээр хэвлэгджээ.<sup>15</sup> Тус өгүүлэлд 1921 онд БНМАУ байгуулагдсаны дараа монголын түүхчид, хятад судлаачдад Юань гүрний үеийн түүх болон Монголын түүхийн талын судалгааг танилцуулжээ. 20-р зууны 20-80-иад оны БНМАУ-ын монголын түүхийн судалгааны үр дүнг тухайлбал: “БНМАУ-ын түүх”,<sup>16</sup> нэгэн боть “Хувьсгалын өмнөх Монголын түүх бичлэгийн асуудал”,<sup>17</sup> “БНМАУ-ын түүх” гурван боть,<sup>18</sup> “Юань гүрний үеийн Монгол”,<sup>19</sup> “Монголд нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь”,<sup>20</sup> “Монголын феодализмын үндсэн замнал”<sup>21</sup> гм. Үүнээс гадна Монголын нэрт хятад судлаач Ч.Дандаагийн /Юань улсын судар/-ын монгол хэл дээр орчуулагдсан байдал нь Хятад улсын эрдэмтэд тухайн үеийн БНМАУ болон Монголын түүх судлалын талаархи шинэ үр дүнг ойлгоход тус болжээ.

1995 онд академич Ч.Далай хятад хэлээр “Монгол улсын

ойрадын судалгаа” гэсэн өгүүлэл бичиж, монгол улсад амьдарч байгаа ойрадуудын байдлыг монгол эрдэмтэд жишээн нь: Ж.Цэвээн, Б.Буянчуулган, Б.Ренчин, Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан, Д.Гонгор, Н.Ишжамц, С.Пүрэвжав, Д.Цэрэнсодном нарын ойрад судлалын талаархи үр дүн хийгээд Монгол улсад хуралдсан ойрадын судалгааны эрдэм шинжилгээний хурлын байдлыг нарийвчлан танилцуулжээ. Үүний зэрэгцээ “Юань улсын түүх”, “Мин улсын түүх”, “Мин улсын магад түүх”, “Мин улсын түүхийн эх адаг”, “Манжийн магад түүх”, “Хааны зарлигаар тогтоосон говийн арын арга бодлого”, “Зарлигаар тогтоосон Зүүнгарын арга бодлого” зэрэг хятад хэл дээрх түүхийн материал тулгуур бичиг нь ойрадын судалгаанд чухал ач холбогдолтой юм. Түүх судлалын талаар Монгол, Хятад хоёр орны эрдэмтдийн үзэл санаа адилгүй байдгийг ч академич Ч.Далай зохиолдоо тусгажээ. Гэвч энэ нь Монгол, Хятад хоёр орны холбогдох салбарын судалгааны үр дүнд нөлөөлсөнгүй. Үүнээс гадна академич Ч.Далай Монгол, Хятад эрдэмтдийн эрдэм шинжилгээний хуралд олонтаа оролцож, Монголын түүх судлалын байдлыг хятадын мэргэжил нэгт эрдэмтдэд цаг тухайд нь танилцуулж байв. Академич Ч.Далай эрдэм шинжилгээний ажлаа 50 гаруй жил хийж, мятаршгүй чармайж, үзэг цаастай нөхөрлөн, Монгол, Хятад хоёр улсын түүхийн ухаан, хятад судлал болон дорно дахины судлалын талаар гарамгай хувь нэмэр оруулжээ. Эрдэмтэн, дипломатчийн хувьд, хятадад арван таван жил ажиллаж, амьдарсан нь академич Ч.Далайг Хятад, Монголын соёлын харилцааны элч болгосон юм. 1958 онд Монгол, Хятадын найрамдлын нийгэмлэг байгуулахад академич Ч.Далай тус нийгэмлэгийн нарийн бичгийн даргаар сонгогджээ. 1959 онд Монголын нэрт түүхч, академич Ш.Нацагдорж болон академич Ч.Далай нар Монгол, Хятадын найрамдлын нийгэмлэгийн

төлөөлөгчийн хувиар Бээжинд айлчлан БНХАУ байгуулагдсаны 10 жилийн ойн баярын ёслолын үйл ажиллагаанд оролцсон юм.

1962 онд академич Ч.Далай БНМАУ-аас БНХАУ-д суух Элчин сайдын Яамны 1-р нарийн бичгийн даргаар Хятад улсад томилогдон 6 жил ажилласан байна. Тэрээр энэ албанд байсан үеэ дурсан: Хятадын 4 том удирдагч Мао Зэдун, Лю Шаоци, Жү Дэ, Жоу Энълай нараас "Эрхэм ноён Ч.Далайд шинэ жилийн баярын хүргэе" гэсэн үсэгтэй торгомсог цаасан дээр бичсэн мэндчилгээг хүлээн авч байлаа" гэжээ.

Үүний дараа 1986-1989 онд академич Ч.Далай Монгол улсаас Хятад улсад суугаа Элчин сайдын Яаманд 1-р нарийн бичгээр дахин ажиллаж байх үедээ дипломат ажлаас гадна, хятадад байгаа боломжоо ашиглан эрдэм шинжилгээ судалгааны ажлаа идэвхитэй хийж байв. Тэрээр удаа дараа Нанжин, Өрөмч, Хөх хот зэрэг газраар явж эрдэм шинжилгээний хуралд оролцжээ. Мөн Ганьсу, Хөх нуур, Өвөр монгол зэрэг газраар эрдэм шинжилгээний эрэл судалгаа хийж монголын түүхийн холбогдолтой чухал материал өдий төдийг цуглуулсан юм.

Өнөөдөр бид Бээжингийн их сургуулийн хашаан дотуур алхаж явахдаа 50 гаруй жилийн өмнөх академич Ч.Далайгийн энд сурч байсан он жилүүдийг санагалзан дурсдаг. Нэг л мэдэхэд академич Ч.Далай маань биднээс салан одоод нэг жил болоход бид түүний эрдэм шинжилгээ судалгаа болон дипломат ажлын талаар энэхүү товч танилцуулга, үнэлэлт бичиж байна. Энэ бэсрэг өгүүлэлд академич Ч.Далайн бүхий л амжилт бүтээлийг багтааж чадаагүй бөгөөд академич Ч.Далайтай холбогдох судалгааг, цаашид ч үргэлжлүүлэн олон зүйлийг хийх хэрэгтэй байна. Бид академич Ч.Далайн шинжлэх ухааны замаар судалгаагаа алхам бүрээр гүнзгийрүүлж судлахыг хүсэн эрмэлзэж байна. Монголын энэхүү нэрт түүхч, дипломатч бидэнд үлгэр жишээ байж хойч үеийн

шилдэг эрдэмтдийг эрдмийн аянд чиглүүлж өгсөн хүн юм.

### Зүүлт тайлбар

1. Бээжингийн их сургуулийн архивт хадгалагдаж байгаа 1952 оны гадаад оюутны нэрсийн жагсаалт болон бүртгэлд тэмдэглэснээр, тухайн үед БНМАУ-аас Ч.Далай, Бандихүү, Гүрбазар нарын гурван оюутан байжээ. Академич Ч.Далай Хятадын шинэ үеийн түүхийн мэргэжилээр, нөгөө хоёр нь хятад хэл, уран зохиолын ангид суралцжээ.

2. Бээжин Их Сургуулийн архивт хадгалагдаж байгаа “Хятадын хэлний мэргэжил дээшлүүлэх ангийн 1953 оны 2-р улирлын оюутны бүртгэл”-д академич Ч.Далайг 1929 онд төрсөн гэж тэмдэглэжээ. “Академич Ч.Далай нь Монголын түүх, дорно дахины судлалын тэргүүлэх эрдэмтэн” гэсэн өгүүлэлд 2000 оны 10 сард академич Ч.Далайг 1930 онд төрсөн гэжээ.

3. Тэр үед Чойбалсангийн Их Сургууль гэсэн нэртэй байжээ.

4. Бээжин Их Сургуулийн архивт: “Бээжин Их Сургуулийн гадаад оюутны зарим асуудлыг шийдвэрлэх арга ба гадаад оюутны нэрсийн жагсаалт” хадгалагдаж байна.

5. Тус зохиолыг Монголын нэрт эрдэмтэн Б.Ренчин, Ц.Дамдинсүрэн нарын удирдлагаар засварлаж хэвлэсэн. Ч.Батзул “Ч.Далай: Чингисийн онгон хаана байгаа нууцыг задруулахгүй” 2007 оны 1-р сарын 20. [www.mongolianews.mn/uuuuudur.php?n=15227](http://www.mongolianews.mn/uuuuudur.php?n=15227) үзнэ үү.

6. “Монголын бөө мөргөлийн товч түүх” Дин Шижэ, Түргэн орчуулав, Бээжин, 1978 он

7. Л.Хайсандай: “Академич Ч.Далай бол монгол түүх, дорно дахин судлалын тэргүүлэх эрдэмтэн мөн” УБ, 2003 он

8. Л.Хайсандай: «Академич Ч.Далай бол монгол түүх, дорно дахин судлалын тэргүүлэх эрдэмтэн мөн» УБ, 2003 он, т.8

9. “Хятад хэлэн дээр байгаа монголын түүхийн сурвалж бичгээс танилцуулах нь” сэтгүүл “Дунд сургууль”, УБ, 1959 он

10. “Юань гүрний үеийн монгол”, эрдэм шинжилгээний удирдагч, Академич: Ш.Нацагдорж, УБ, 1970 он.

11. Ч.Далай, И.Шима: “Монгол, Хятадын харилцаа: 1949-1984” (орос хэлээр), Прага, 1986 он

12. “БНМАУ дахь хятад судлал”, “ШУА-ийн мэдээ” №1, УБ, 1961 он

13. “Хятад, Япон дахь хятад судлал”, УБ, 1988 он

14. “xibeí minzu yanjiú” (Баруун хойг Хятадын үндэстний судалгаа), 1995 он, №1, 152-157, 243-р тал

15. “xibeí minzu yanjiú” (үндэстний судалгаа), 1991 он. № 1, 91-94 –р тал

16. “БНМАУ-ын түүх” нэгэн боть ЗХУ-ын ШУА, БНМАУ-ын ШУА-ын эрдмийн зөвлөлийн хамтарсан бүтээл, 1954 он

17. Х.Пэрлээ, “Хувьсгалын өмнөх Монголын түүх бичлэгийн асуудал” УБ, 1958 он.

18. “БНМАУ-ын түүх” 3 боть, Монголын ШУА-ын бүтээл, 1966-1969 он.

19. Ч.Далай. “Юань гүрний үеийн Монгол”, УБ, 1973 он.

20. Н.Ишжамц. “Монголд нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь” УБ, 1974 он.

21. Ш.Нацагдорж. “Монголын феодализмын үндсэн замнал”, УБ, 1978 он.

### Лавлах эх сурвалж:

#### Монгол хэлээр:

1. Л.Хайсандай: «Академич Ч.Далай бол монгол түүх, дорно дахин судлалын тэргүүлэх эрдэмтэн мөн» УБ, 2003 он

2. Ч.Далай: “Монгол бөөгийн мөргөлийн товч түүх” УБ, 1959 он

3. Ч.Далай: “Юань гүрний үеийн монгол”, эрдэм шинжилгээний удирдагч, академич Ш.Нацагдорж, УБ, 1970 он

4. Ч.Далай: “Хятад, Япон дахь хятад судлал”, УБ, 1988 он

5. Ч. Далай: “Хятад хэлэн дээр байгаа монголын түүхийн сурвалж бичгээс танилцуулах нь” сэтгүүл «Дунд сургууль», УБ, 1959 он

6. Ч.Батзул: “Чингисийн онгон хаана байгаа нууцыг задруулахгүй” 2007 оны 1 сарын 20 –нд,

[www.mongolianews.mn/unuudur.php?n=15227](http://www.mongolianews.mn/unuudur.php?n=15227).

7. У. Амарсайхан: “Хятад хүнтэй харилцах ухаан” (Академич Ч.Далайтай хийсэн ярилцлага) “Хөдөлмөр сонин” 1992.3.8 №7

Хятад хэлээр:

1. Ч.Далай: “БНМАУ-ын Юан гүрний судалгаа ба (Юань Ши)-г монгол хэлнээ орчуулсан нь”, “xibei minzu yanjiu” (баруун хойт хятадын үндэстний судалгаа) сэтгүүл, 1991 он, №1.

2. Ч.Далай: “Монгол Улс дахь ойрадын судалгаа”, “xibei minzu yanjiu” (баруун хойт хятадын үндэстний судалгаа) сэтгүүл, 1995 он, №1

3. Бээжингийн их сургуулийн архивт хадгалагдаж буй “1952 оны гадаад оюутны нэрсийн жагсаалт ба бүртгэлийн хүснэгт”

*Хятад хэлнээс орчуулсан  
“Түгээмэл” дээд сургуулийн хятад хэлний  
багш Дамдинсүрэнгийн Батжаргал,  
Л.Бэгзжав  
2010.11.12*